

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2020 оны 06 дугаар сарын 22-ны өдөр
Тендер шалгаруулалтын нэр: **Бутлах хэсгийн цахилгаан тоног төхөөрөмжид зөөлөн асаалтын систем болон давтамж хувиргуур суурилуулах, нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **МРЦМ202004403**

“Монголросцветмет” ТӨҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос бутлах хэсгийн цахилгаан тоног төхөөрөмжид зөөлөн асаалтын систем болон давтамж хувиргуур суурилуулах, нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерт оролцох хүсэлтэй байгууллагууд тендерийн баримт бичгээ илгээхийн өмнө эргэн төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **50,000.00 /тавин мянган/** төгрөг төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 оны аль нэгд гүйцэтгэсэн борлуулалтын хэмжээ тендерийн үнийн саналын мөнгөн дүнгийн 50%-иас багагүй байна.**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт ирүүлсэн үнийн саналын мөнгөн дүнгийн 100 хувиас багагүй байна.**

Тендерийн хамт **2 000 000** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн 14:00 цагаас өмнө www.tender.gov.mn хаягаар ирүүлэх ба мөн өдрийн 14:05 цагт цахим системээр нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Зөвшөөрөхгүй.**

Дотоодын давуу эрх тооцох эсэх. **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, БЗД 22-р хороо, Энхтайваны өргөн чөлөө – 98, 409 тоот өрөө, утас:
450060 + 188

“МОНГОЛРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ